

**2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД ДҮҮРГИЙН УДИРДАХ
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, 2023 оны 10 дугаар сарын 25-ны “Лхагва” гарагт өмнө e-doc системээр албан бичгээр ирүүлж, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажлын байр, чиг үүргийн давхардалд, ажил үүргийн уялдаа холбооны талаар дүгнэлт гаргаж танилцуулах.	ТЗУХ
2	Багахангай, Багануур, Налайх дүүргүүдийн нутаг дэвсгэрт 20-30 мянга орчим нохой, муур тэжээдэг, байршуулдаг газар болон бүртгэлжүүлэх, хаягжуулах зэрэг ажлын төсөв, тооцоо судалгаа хийж танилцуулах.	ТХҮХ, МЭТ
3	Нийслэлээс мал гаргах ажлыг шуурхай зохион байгуулж, хотоос гаргасан малуудыг хотоос зайдуухан нэг байршилд төвлөрүүлж, тухайн төвлөрүүлсэн байршлаас малыг эзэнд нь хүлээлгэж өгөхдөө нөхөн төлбөр авах, жишиг тариф гаргах захирамжийн төслийг боловсруулж танилцуулах.	ХААТ
4	Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг компаниудын үр тариа, хор цацдаг машин, тоног төхөөрөмжүүдийг давс цацахад ашиглаж болох асуудлыг судалж, танилцуулах.	ТХҮХ
5	Дүүргийн Засаг дарга нарт хот нийтийн аж ахуйн чиг үүргүүдийг шилжүүлэх ажлыг яаралтай танилцуулах, Мөн хот нийтийн аж ахуйн тусгай зориулалтын авто машинуудын стандартыг шинэчлэх асуудлыг судалж танилцуулах.	ТХҮХ
6	Асахгүй байгаа гэрэлтүүлгийг засварлан асалтыг 100 хувьд хүргэх	Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
7	Төсвийн орлого бүрдүүлэгч байгууллагууд төсвийн орлого бүрдүүлэхэд онцгой анхаарч ажиллах.	СТСХ, Татварын хэлтэс, орлого бүрдүүлэгч байгууллагууд
8	Нийслэлийн 2024 оны төсвийн төслийн бэлтгэл ажлыг сайтар хангах.	СТСХ
9	Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажилд холбогдох саналыг хүргүүлж ажиллах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц, ТЗУХ
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР		
10	2023.10.19-ний өдөр зохион байгуулагдах Цэрэг татлагын арга хэмжээнд томилгоожсон албан хаагчид идэвхтэй оролцох, цэргийн насны албан хаагчид болон иргэдийг идэвхтэй хамруулах.	ААНБ, Хороод
11	Өвөлжилтийн бэлтгэл ажлыг сайтар хангаж ажиллах.	ТХҮХ, дэд бүтцийн байгууллагууд
12	Нийслэлийн багц хуульд тусгуулах саналыг НЗДТГ-ын даргад хүргүүлэх.	ТЗУХ
13	Дүүргийн 2 болон 4 дүгээр байрнуудад байрлах гэрлэн чимэглэл бүхий хаягуудыг засварлан бүрэн асаах.	Багахангай гэрэлтүүлэг, ногоон

		байгууламж ОНӨААТҮГ
14	Нийслэлийн 384 жилийн ойн өдрийг угтсан бүх нийтийн цэвэрлэгээг чанартай зохион байгуулах.	Нийт ААНБ-ууд, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
15	Хөрөнгө оруулалтын ажлуудыг эрчимжүүлэх, сургуулийн орчмын зам засварын ажил эхлэхтэй холбогдуулан аюулгүйн зөвлөмжийг сурагч, эцэг эхчүүдэд хүргэж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	ТХҮХ, СТСХ, ХААА, ХЦС
16	Вакум сургалтыг зохион байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх.	НХХ, Боловсролын хэлтэс

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР